



MONGOLIAN CASHMERE

МОНГОЛ УЛС
“ГОВЬ” ХУВЬЦААТ КОМПАНИ
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

20~~22~~ оны 03 сарын 11-ны өдөр

Дугаар 05

Улаанбаатар хот

**Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг
зарлан хуралдуулах тухай**

Говь ХК-ийн 2022 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдах асуудлыг хэлэлцэн, Компанийн тухай хуулийн 60, 64, 65 дугаар зүйл, Компанийн дүрмийн 6.2.7.3, 6.2.7.4 дэх заалтыг тус тус үндэслэн Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ нь:**

Нэг. Говь ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг **2022 оны 4-р сарын 23-ны Бямба гарагийн 11:00 цагт** Говь ХК-ийн төв дэлгүүрийн дэргэдэх “Мираж” ресторанд хуралдуулсугай. Хурлыг ТУЗ-ийн дарга Д.Гэрэлмаа даргалсугай.

Хоёр. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2022 оны 3-р сарын 31-ний өдрөөр тогтоож, “Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдэл”-ийг Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржид 2022 оны 3-р сарын 14-ний өдөр хүргүүлэн, хурлын зарыг Санхүүгийн зохицуулах хорооноос гаргасан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ын дагуу 2022 оны 3-р сарын 16 болон 3-р сарын 31-ний өдрүүдэд олон нийтэд зарласугай.

Гурав. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудал, гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичгийг 2022 оны 3-р сарын 21-ний өдрийн дотор брокер дилерийн компаниудад хэвлэмэл болон цахим хэлбэрээр хүргүүлэхээр тогтоосугай.

Дөрөв. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудлыг 1 дүгээр хавсралтаар баталсугай.

Тав. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох бичиг баримтын жагсаалт, уг бичиг баримттай танилцаж болох газар, хугацааг 2 дугаар хавсралтаар баталсугай.

Зургаа. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэгийг 3 дугаар хавсралтаар баталсугай.



МОНГОЛ УЛС
“ГОВЬ” ХУВЬЦААТ КОМПАНИ
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

MONGOLIAN CASHMERE

2022 оны 03 сарын 11-ны өдөр

Дугаар 05

Улаанбаатар хот

Долоо. Хурлын өдөр ирсэн хувьцаа эзэмшигчдээс саналын хуудсаар санал авахаас гадна компанийн шуудангийн хаягаар болон брокер дилерийн компаниар дамжуулан урьдчилан санал авах сүүлчийн өдрийг 2022 оны 4-р сарын 21-ний өдрөөр тогтоож, санал авах хуудасны агуулга, загварыг 4 дүгээр хавсралтаар баталсугай.

Найм. Олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлах хэвлэлийн эхийг 5 дугаар хавсралтаар баталсугай.

Ес. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зохион байгуулах комиссыг дор дурдсан бүрэлдэхүүнтэйгээр байгуулж, хурлыг зохион байгуулах, танилцуулах болон хэлэлцэх асуудлын бэлтгэлийг хангаж ажиллахыг комиссын дарга Ч.Солонго-д даалгасугай.

Комиссын дарга:	Тэргүүн дэд захирал	Ч.Солонго
Гишүүд:	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга	М.Сэлэнгэ
	ТУЗ-ийн мэргэжилтэн	Б.Нарантуяа
	Мэдээлэл технологи хариуцсан захирал	Э.Уртнасан

ТУЗ-ийн ДАРГА:

ТУЗ-ийн ГИШҮҮД:



Д.ГЭРЭЛМАА

Ц.БААТАРСАЙХАН

М.БАЯР

Б.НАНДИН-ЭРДЭНЭ

Ж.ОЮУНЧИМЭГ

А.ЖАРГАЛМАА

ТАКЭШИ КАМБЭ

ХИДЭО САВАДА

Д.ХУЛАН

Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
2021 оны 03 сарын 11 -ний өдрийн хурлын
Төлөөлөн Удирдах Зөвлөл
05-р тогтоолын 1-р хавсралт



ГОВЬ ХУВЬЦААТ КОМПАНИЙН

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ

1. Говь ХК-ийн 2021 оны үйл ажиллагаа болон санхүү үр дүнгийн тайланг танилцуулах
2. Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс компанийн 2021 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн талаар гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах
3. 2021 оны санхүүгийн үр дүнгээс ногдол ашиг хуваарилахгүй тухай Төлөөлөн Удирдах Зөвлөлийн тогтоолыг танилцуулах
4. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2021 оны ажлын тайланг танилцуулах



**ХУРАЛД ОРОЛЦОХ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ТАНИЛЦАЖ
БОЛОХ БИЧИГ БАРИМТЫН ЖАГСААЛТ, УГ БИЧИГ БАРИМТТАЙ
ТАНИЛЦАЖ БОЛОХ ГАЗАР, ХУГАЦАА**

1. Хувьцаа эзэмшигчид нь дор дурдсан бичиг баримттай танилцаж болно. Үүнд:
 - Компанийн санхүүгийн жилийн тайлан
 - Санхүүгийн жилийн тайлангийн талаарх хөндлөнгийн аудитын байгууллагын дүгнэлт
 - Тайлангийн жилд хийгдсэн сонирхлын зөрчилтэй хэлцэл, түүнийг компанийн тухай хуульд заасан журмын дагуу хийгдсэн эсэх тухай хөндлөнгийн аудитын байгууллагын дүгнэлт
 - Компанийн нэгдмэл сонирхолтой этгээдүүд, тэдгээрийн эзэмшиж байгаа хувьцааны төрөл, тоо
 - Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх удирдлагын цалин, урамшуулал, бусад зардал
 - Компанийн бизнесийн үйл ажиллагааны тайлан
 - Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарах тогтоолын төсөл
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох хувьцаа эзэмшигчид нь 2022 оны 3-р сарын 21-ний өдрөөс эхлэн дараах арга хэлбэрээр хурлын материал болон холбогдох бичиг баримттай танилцаж болно. Үүнд:
 - Монголын хөрөнгийн биржийн цахим хуудас (www.mse.mn/mn/company/354);
 - Говь ХК-ийн цахим хуудас (info.gobi.mn);
 - Өөрийн харилцаж буй брокер дилерийн компаниасаа цахимаар болон биечлэн очиж;
 - Говь ХК-ийн төв байранд байрлах Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргын өрөөнд ажлын өдрүүдийн 08:00-16:00 цагийн хооронд ирж танилцах боломжтой.

ТӨЛӨӨЛӨН
УДИРДАХ
ЗӨВЛӨЛ

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ДЭГ

1. Хурлын ирцийг гаргаж хурлын даргад мэдэгдэх
/Тооллогын комиссын дарга Н.Сайнзул/ 3 минут
2. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг нээж, хурлын дэгийг танилцуулах
/ТУЗ-ийн дарга Д.Гэрэлмаа/ 3 минут
3. Тооллогын комиссыг томилсон тухай ТУЗ-ийн тогтоолыг танилцуулах
/ТУЗ-ийн нарийн бичгийн дарга М.Сэлэнгэ/ 3 минут
4. Хэлэлцэх асуудлын төлөвлөгөөний дагуу дараах илтгэлүүдийг тавина:
 - 4.1. Компанийн 2021 оны үйл ажиллагаа болон санхүү үр дүнгийн тайланг танилцуулах
/Тэргүүн дэд захирал Ч.Солонго/ 20 минут
 - 4.2. ТУЗ-өөс компанийн 2021 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн талаар гаргасан дүгнэлтийг танилцуулах
/ТУЗ-ийн дарга Д.Гэрэлмаа/ 10 минут
 - 4.3. 2021 оны санхүүгийн үр дүнгээс ногдол ашиг хуваарилахгүй тухай ТУЗ-ийн тогтоолыг танилцуулах
/ТУЗ-ийн нарийн бичгийн дарга М.Сэлэнгэ/ 3 минут
 - 4.4. ТУЗ-ийн 2021 оны ажлын тайланг танилцуулах
/ТУЗ-ийн дарга Д.Гэрэлмаа/ 10 минут
5. Хэлэлцэж буй асуудалтай холбоотой асуулт, хариулт
/хүн тус бүр 2 минут/ 20 минут
6. Саналын хуудсаар санал авах 10 минут
7. Завсарлага 15 минут
8. Санал хураалтын дүнг нэгтгэн, тооллогын комисс санал хураалтын дүнг танилцуулж, тооллогын комиссын тогтоолыг батлуулах 3 минут
9. Хурлаас гарах тогтоолын төсөлд Тооллогын комиссын санал хураалтын дүнг тусган танилцуулж, тогтоолыг батлуулах
/ТУЗ-ийн нарийн бичгийн дарга М.Сэлэнгэ/ 3 минут

Хурлын үргэлжлэх хугацаа: 2 цаг

Жич: Хэрэв шаардлагатай бол хурлын хугацааг хэлэлцэн сунгаж болно.



“ГОВЬ” ХК-ийн ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН
ЭЗЭЛЖИГ ХҮҮРЛЫН САНАЛ АВАХ ХУДАС

“Говь” ХК-ийн дүвчлэл эзэмшлэгчийн эзэмшил зурлын өдөр: 2022 оны 04 сарын 23-ны өдөр
Эзлэх цаг: 11:00 цаг
Байршил: Төв, ХК-ийн Төв дэвсгэрийн дэрсэдэх “Мираж” ресторан

Хувьцаа эзэмшигчийн овог нэр элгийн
Регистрийн дугаар төрөл
Эзэмшигч буй хувьцааны тоо

№	Шийдвэр гаргаж, батлах асуулгын нэр	Хурмаас гаргах шийдвэрийн төсөл	Зөвшөөрсөн	Татгалзсан	Татгалзсан тохиолдол тална өгөх санал
1	Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлагнагчид талварх ГУЗ-ийн дүгнэлтийг батлах	ГУЗ-ийн дүгнэлт: Өөрсдийн мөөг боловцоог бүрэн дүүрэн ашиглан ажилласан			

2022 оны ...-р сарын ...-ны өдөр

Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг

Тоглогчид комисс бөглөх хэсэг:


Хувьцаа эзэмшигчийн бүртгэлийн дугаар:

Саналын хуудсыг хүчингэйд тооцон тоолсон эсэх: Тийм Угүй

Саналын хуудсыг хүчингэйд тооцсон бөл шалтгаан:

САНАЛ АВАХ ХУУДСЫГ АШИГЛАХ САНАМЖ

1. Санал авах хуудсыг ларах замарын ялгуу бөглөнө.
 - Саналын хувилбарын зөвхөн нэгийг сонгож, (✓) тэмдэг тавина
 - Жишээ нр.: зөвшөөрсөн бол “Зөвшөөрсөн” гэсэн нүдэнд (✓), татгалзсан бол “Татгалзсан” гэсэн нүдэнд (✓), татгалзсан бол Түгэлзсэн гэсэн нүдэнд (✓) тэмдэг тавина.
 - Хэрэв та хэлцэнэж буй асуулгын шийдвэрийн төслийг татгалзсан саналтай байгаа бол “Тална өгөх санал” гэсэн нүдэнд уг асуулгыг мурхи шийдвэрлэх саналтай байгаага бичнэ.
 - Зөвлөрсөн, батласан, (✓)-ээс өөр тэмдэгтээ хэрэглэсэн болон аль нэг саналыг бөглөөгүй саналын хуудсыг хүчингүйд тооцно.
2. Хэрэв та саналын хуудсар урьдчилан саналаа өгөх бол хурлын материалыг танилцаад, санал авах хуудсанд саналаа тэмдэглэж, өөрийн харилцаа брокер шилэрийн компаниараа дамжуулан өгөх. компани дээр бичигдэн ирж өгөх хэвэл Улаанбаатар-17062, Шуудангийн хайрцаг-36/434, “Говь” ХК хаягаар 2022 оны 04 сарын 21-ний өдрийн дотор иргүүлнэ үү.
3. Хэрэв та саналаа өөр хүчээр төлөөлүүлэн өгөх бол төлөөлөх хүндээ итгэмжлэл бичиж өгөж, нотархаар баталгаажуулсан байна.





Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
2022 оны 03 сарын 11-ний өдрийн хурлын
05-р тогтоолын 5-р хавсралт

/Хэвлэл мэдээллийн эх/

“ГОВЬ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

Говь ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал **2022 оны 4-р сарын 23-ны өдрийн 11:00 цагт Говь ХК-ийн төв дэлгүүрийн дэргэдэх “Мираж” ресторанд** болох тул хувьцаа эзэмшигч та бүхнийг хуралд оролцохыг урьж байна.

Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр: **2022 оны 3-р сарын 31-ний өдөр.**

Хурлаар хэлэлцэх асуудал:

1. Говь ХК-ийн 2021 оны үйл ажиллагаа болон санхүү үр дүнгийн тайланг танилцуулах
2. Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс компанийн 2021 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн талаар гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах
3. 2021 оны санхүүгийн үр дүнгээс ногдол ашиг хуваарилахгүй тухай Төлөөлөн Удирдах Зөвлөлийн тогтоолыг танилцуулах
4. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2021 оны ажлын тайланг танилцуулах

Хурлын материалтай танилцах:

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох хувьцаа эзэмшигчид нь **2022 оны 3-р сарын 21-ний өдрөөс эхлэн** дараах арга хэлбэрээр хурлын материал болон холбогдох бичиг баримттай танилцаж болно. Үүнд:

- Монголын хөрөнгийн биржийн цахим хуудас (www.mse.mn/mn/company/354);
- Говь ХК-ийн цахим хуудас (info.gobi.mn);
- Өөрийн харилцаж буй брокер дилерийн компаниасаа цахимаар болон биечлэн очиж;
- Говь ХК-ийн төв байранд байрлах Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргын өрөөнд ажлын өдрүүдийн 08:00-16:00 цагийн хооронд ирж танилцах боломжтой.

Урьдчилан санал өгөх:

Хуралд биечлэн оролцох боломжгүй, урьдчилан санал өгөх хувьцаа эзэмшигч хурлын материалтай танилцан, саналын хуудсыг бөглөж өөрийн харилцаж брокер, дилерийн компаниараа дамжуулан өгөх, компани дээр биечлэн ирж өгөх эсвэл Говь ХК-ийн шуудангийн хаягаар **2021 оны 4-р сарын 21-ний өдрөөс өмнө** ирүүлнэ үү.

Жич: Хувьцаа эзэмшигчдийн хурлын ирцийн бүртгэл **2022 оны 4-р сарын 23-ны 10:00 цагт эхлэн 11:00 цагт дуусах** тул та бүхэн цагтаа цуглана уу.

Холбоо барих:

Хурал зохион байгуулах комисс	Нэр	Утас	И-Мэйл
ТУЗ-ийн нарийн бичгийн дарга	М.Сэлэнгэ	9411-8277	boardsecretary@gobi.mn
ТУЗ-ийн мэргэжилтэн	Б.Нарантуяа	9990-0475	boardoffice@gobi.mn

Говь ХК-ийн албан ёсны хаяг:

Улаанбаатар - 17062, Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Үйлдвэрийн гудамж, Говь ХК
Утас: 7013-9977, Факс: 7014-3081
Шуудангийн хайрцаг: 36/434, Говь ХК



MONGOLIAN CASHMERE

МОНГОЛ УЛС
“ГОВЬ” ХУВЬЦААТ КОМПАНИ
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

20~~22~~ оны ~~03~~ сарын ~~11~~-ны өдөр

Дугаар ~~06~~

Улаанбаатар хот

Тооллогын комисс томилох тухай

Говь ХК-ийн 2022 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдахтай холбогдон Тооллогын комиссыг томилох тухай асуудлыг хэлэлцэн, Компанийн тухай хуулийн 67.1 дэх заалт, Компанийн дүрмийн 6.1.4.9 дэх заалтыг тус тус үндэслэн Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ нь:**

Нэг. Говь ХК-ийн 2022 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай:

Комиссын дарга: Н.Сайнзул – Дотоод аудитын хэлтсийн дарга
Нарийн бичгийн дарга: Ц.Цэцэгбадам – Үйлдвэр бүртгэлийн албаны дарга
Гишүүд: Т.Мөнхзул – Ахлах аудитор
Б.Уянга – Хүний нөөцийн хэлтсийн дарга
Г.Ганзаяа - Программын төслийн менежер
Г.Золзаяа – Үйлдвэр хариуцсан нягтлан бодогч

Хоёр. Тооллогын комисс (Н.Сайнзул)-д даалгах нь:

1. Хурлын ирцийг бүртгэж хурлын даргад мэдээлэх;
2. Хурлаар хэлэлцэх асуудал тус бүрээр саналын эрхтэй байх хувьцааны тоо, төрлийг тодорхойлох;
3. Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож, санал өгөх эрхээ хэрэгжүүлэхтэй холбогдон гарах аливаа асуултад тайлбар өгөх;
4. Санал өгөх журмыг тайлбарлах, хувьцаа эзэмшигчдийн санал өгөх эрхийг хангах;
5. Хувьцаа эзэмшигчид цахим санал хураалтад оролцох бүртгэлийг хийх;
6. Саналын хуудсыг хайрцгаар мөн цахим хэлбэрээр авах;
7. Саналыг тоолж, энэ тухай тэмдэглэл хөтлөх;
8. Саналын дүнг нэгтгэн, санал хураалтын дүнгийн тухай тооллогын комиссын шийдвэрийг хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулах;



MONGOLIAN CASHMERE

МОНГОЛ УЛС
“ГОВЬ” ХУВЬЦААТ КОМПАНИ
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 03 сарын 11-ны өдөр

Дугаар 06

Улаанбаатар хот

ТУЗ-ийн ДАРГА:

ТУЗ-ийн ГИШҮҮД:



 Д.ГЭРЭЛМАА

 Ц.БААТАРСАЙХАН

 М.БАЯР

 Б.НАНДИН-ЭРДЭНЭ

 Ж.ОЮУНЧИМЭГ

 А.ЖАРГАЛМАА

 ТАКЭШИ КАМБЭ

 ХИДЭО САВАДА

 Д.ХУЛАН